



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
С.ЭНХБОЛД ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2022 04 22 № 02 / 5550.
танай _____ -ны № _____ -т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Авлигатай тэмцэх газар нь төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, хүртээмжтэй болгох, авлигын эрсдэл, шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, арилгах, дүн шинжилгээ хийх, шийдвэрлэх арга замыг тодорхойлох, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж өгөх, арга зүйн туслалцаа үзүүлэх зэрэг арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж байна.

Энэ хүрээнд эрүүл мэндийн байгууллагын шударга байдлыг нэмэгдүүлэх, 2019 онд зохион байгуулсан "Төрийн байгууллага дахь авлигын эрсдэлийн үнэлгээ"-ний мөрөөр хүргүүлсэн зөвлөмжийн биелэлттэй газар дээр нь танилцах, эрүүл мэндийн байгууллагад шинэ тутам хэрэгжиж буй эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа, үр нөлөө, авч хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний хэрэгжилттэй танилцах зорилгоор Улсын нэгдүгээр төв эмнэлэгт ажиллахад авлига, ашиг сонирхлын зөрчил гарах эрсдэл үүссэн байх тул албан зөвлөмж хүргүүлж байна.

Зөвлөмжид дурдсан авлигын гэмт хэрэг, зөрчил гарах эрсдэл бусад эрүүл мэндийн байгууллагуудад гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор салбарын яам бодлогын түвшинд авч үзэж, бодитой ажил зохион байгуулан, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасны дагуу биелэлт, үр дүнгийн талаар 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн дотор хариу ирүүлнэ үү.

Хувийг. Монгол Улсын Ерөнхий сайд танаа.

Хавсралт 22 хуудаастай.

ДЭД ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Г.АЗЖАРГАЛ

142203008788

Авлигатай тэмцэх газрын
2022 оны 04 дүгээр сарын 22-ны
өдрийн 02 дугаар албан бичгийн
хавсралт

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ЗӨВЛӨМЖ

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зөвлөмж 1. Эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн Хамт олныг төлөөлөх 3 гишүүнийг хуульд заасны дагуу албан хаагчдад нэр дэвших боломжийг олгож, ил тод нээлтэй байдлаар зохион байгуулж, үр дүнг мэдээлэх.

Тухайн эмнэлгийн хамт олныг төлөөлөх ТУЗ-ийн 3 гишүүнд тус эмнэлгийн эмч нараас Урологи, андрологийн төвийн дарга Д.Баян-Өндөр, сувилагч, тусгай мэргэжилтэн М.Дуламсүрэн, Аж ахуй, үйлчилгээний албаны дарга Б.Түвшинтөр нарыг сонгохдоо Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.28-д заасны дагуу "...шалгуурыг хангасан нэр дэвшигчийг танилцуулж, илээр санал хурван олонхын санал авсан нэр дэвшигчийг сонгоно..." гэж заасныг баримтлан 3 гишүүнийг сонгох хурал тусгайлан зохион байгуулаагүй, "Бөөр шилжүүлэн суулгах" арга хэмжээний дундуур нэр төдий зохион байгуулж, хамт олноос санал авалгүйгээр сонгосон гэж үзэхээр байна.

Тухайлбал, тус эмнэлэгт 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Бөөр шилжүүлэн суулгах хагалгаа хийгдсэний 200 дахь хагалгааг тэмдэглэн УНТЭ-ийн хүндэт дэвтэрт бичих, алдаршуулах баярын арга хэмжээ зохион байгуулах үеэр тус эмнэлгийн даргаар ажиллаж байсан Т.Мөнхсайхан Эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл байгуулах талаар албан хаагч нарт танилцуулж, өөрийн зүгээс Урологи, андрологийн төвийн дарга Д.Баян-Өндөр, сувилагч М.Дуламсүрэн, аж ахуй, үйлчилгээний албаны дарга Б.Түвшинтөр нарыг нэр дэвшүүлж байгааг зарлаж, албан хаагч нараас өөр хүн нэр дэвшүүлэх эсэх талаар асуухад албан хаагчид өөр албан хаагч дэвшүүлэх талаар санал гаргаагүй байна. Өөрөөр хэлбэл эмнэлгийн тасаг, нэгжүүдэд албан ёсоор мэдээлэл хүргээгүй, тасаг, нэгжүүд дотооддоо нэр дэвшигчийг сонгох, санал авах нөхцөлийг бүрдүүлээгүй нь албан хаагчид өөрсдийгөө төлөөлөх, ажилтныг сонгож дэвшүүлэх боломжийг ажилтнуудад олгоогүй байна.

Мөн тус эмнэлгийн даргаар ажиллаж байсан Т.Мөнхсайхан нь ТУЗ-ийн гишүүнд дээрх баярын арга хэмжээнд тус эмнэлгийн Аж ахуй, үйлчилгээний албаны дарга Б.Түвшинтөрийг эмнэлгийн хамт олныг төлөөлөх ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлсэн. Б.Түвшинтөр нь тус Эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлд ажиллахад Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т заасан "нийгмийн эрүүл мэнд болон анагаах ухааны боловсролтой, ...эрүүл мэндийн салбарт ажилласан туршлагатай байх;" шалгуурыг хангахгүй, өмнө нь эрүүл мэндийн салбарт ажилласан туршлагагүй этгээд байна. Хамт олныг төлөөлөх эмнэлгийн мэргэжилтэн Б.Түвшинтөрийг 2020 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн Б/496 дугаар тушаалаар Аж ахуй, үйлчилгээний албаны даргын албан тушаалаас чөлөөлж, 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс Төлөвлөлт, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирлын албан тушаалд томилсон байна. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.11.3-д "гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх, үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох"-ыг хориглох гэж заасан бөгөөд хамт олныг төлөөлөх эмнэлгийн мэргэжилтэн Б.Түвшинтөр нь Төлөвлөлт, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирлын албан тушаал хашиж байгаа нь эмнэлгийн гүйцэтгэх удирдлагын эрх хэрэгжүүлэх нөхцөл бүрдэж, эмнэлгийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох нөхцөл бүрдсэн нь авлигын гэмт хэрэг, хувийн ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл бүрдсэн гэж үзэхээр байна.

Зөвлөмж 2. Эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн Олон нийтийг төлөөлөх 3 гишүүнийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг олон нийтэд ил тод байдлаар зохион байгуулан, үр дүнг танилцуулах.

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Олон нийтийг төлөөлөх гишүүдэд Даатгуулагчийн олонхын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагын төлөөлөл "Монголын хүүхдийн анагаахын академи" төрийн бус байгууллын гишүүн Д.Оргилмаа, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, төрийн бус байгууллагын төлөөлөл "Монголын анагаах

ухааны биологийн соронзон резонансын нийгэмлэг” төрийн бус байгууллагын гишүүн Ш.Уранчимэг, эрүүл мэндийн мэргэжлийн нийгэмлэг, холбоо, мэргэжлийн салбар зөвлөлийн төлөөлөл “Монголын мэдрэл, толгой, хүзүүний дүрслэл оношилгооны нийгэмлэг” төрийн бус байгууллагын санхүү хариуцсан менежер Д.Тэмүүлэн нарыг тус тус 3 жилийн хугацаатай томилсон байна.

Олон нийтийг төлөөлөх гишүүдийг сонгох үйл ажиллагаатай танилцахад ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шаардлага хуульд нийцээгүй, ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг сонгон шалгаруулсан, сонгон шалгаруулалтын дүнг олон нийтэд ил тод мэдээлээгүй, сонгон шалгаруулалтын хурлын тэмдэглэл, нэр дэвшигч байгууллагуудаас ирүүлсэн материал эх хувиараа олдоогүй зэрэг зөрчлүүд байна. Тухайлбал,

- Эрүүл мэндийн яамнаас сонгон шалгаруулалтын зарыг “Өдрийн сонин”-ы 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн №002 /6368/ дугаарт “Сонгон шалгаруулалтын урилга” байршуулж, уг урилгын шаардлага хэсэгт *“тухайн эмнэлэгтэй ашиг сонирхлын зөрчилгүй байх /Улсын нэгдүгээр төв эмнэлгээс тухайн эмнэлэгтэй ашиг сонирхлын зөрчилгүй талаарх тодорхойлолт гаргуулж, ирүүлэх/”* гэсэн хуульд тусгагдаагүй шаардлагыг Эрүүл мэндийн яам зарлалд оруулан олон нийтэд хүргэсэн байна.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.26-д эмнэлгийн ТУЗ-ийн олон нийтийн төлөөлөлд нэр дэвшүүлэх төрийн бус байгууллагад тавигдах шаардлагыг тусгасан бөгөөд уг зүйлийн 15.26.2-т нэр дэвшигч *“тухайн эмнэлэгтэй ашиг сонирхлын зөрчилгүй”* байх гэж заасан. Гэтэл тухайн эмнэлгийн удирдлага хуулийг дураараа тайлбарлан тухайн эмнэлгээс ашиг сонирхлын зөрчилгүй талаарх тодорхойлолт гаргуулан авах болгон өөрчилсөн байна. Тухайн эмнэлэгтэй ашиг сонирхлын зөрчилтэй эсэх тодорхойлолтыг эрүүл мэндийн байгууллага олгох эрх эмнэлгийн удирдлагад хуулиар олгогдоогүй бөгөөд нэр дэвшигч томилогдохоор олонхын санал авсан тохиолдолд Авлигатай тэмцэх газарт ашиг сонирхлын зөрчлийн урьдчилсан мэдүүлгээ хянуулан холбогдох дүгнэлтийг гаргуулдаг хуулийн зохицуулалттай. Гэтэл Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байсан Т.Мөнхсайхан нь тус эмнэлгийн ТУЗ-ийн олон нийтийг төлөөлөх гишүүнд нэр дэвшигч “Монголын анагаах ухааны биологийн соронзон резонансын нийгэмлэг” ТББ, “Монголын хүүхдийн анагаахын академи” ТББ, “Монголын мэдрэл, толгой, хүзүүний дүрслэл оношилгооны нийгэмлэг” ТББ-ууд тодорхойлолт авах хүсэлт ирүүлээгүй байхад 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр *“Улсын нэгдүгээр төв эмнэлэгтэй ашиг сонирхлын зөрчилгүй болохыг тодорхойлов”* гэсэн тодорхойлолтыг гаргаж өгсөн байна. Ажлын хэсэг дээрх төрийн бус байгууллагууд ашиг сонирхлын зөрчилгүй гэх тодорхойлолт авах талаар албан ёсоор хүсэлт ирүүлсэн эсэхийг шалгах явцад тус эмнэлгийн Захиргаа, хүний нөөцийн албаны ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, бичиг хэргийн эрхлэгч С.Хулан дээрх төрийн бус байгууллагаас ирүүлсэн хүсэлт гэх хуурамч материалыг ажлын хэсэгт танилцуулсан.

Харин ТУЗ-ийн гишүүнд зэрэг нэр дэвшиж байсан 5 төрийн бус байгууллагад шаардлагатай хугацаанд нь тодорхойлолт гаргаж өгөөгүй буюу “Монголын ерхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо” ТББ, “Өвчтөн нийгмийн төлөөллийн зөвлөл элэг бүтэн монгол” ТББ, “Монголын эмнэлгийн инженерчлэлийн холбоо” ТББ, “Монголын мэс засалч эмч нарын холбоо” ТББ, “Эрүүл мэндийн чанарын менежерүүдийн холбоо” гэсэн төрийн бус байгууллагуудад Эрүүл мэндийн яамнаас зарласан материал хүлээн авах эцсийн өдөр буюу 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 17 цаг 30 минутаас хойш буюу 22-ны өдөр хариуг албан тоотоор өгчээ.

Үүний дараа Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Цогтбаатараас 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 5/471 дугаар “Мэдэгдэл хүргүүлэх тухай” албан бичгээр ашиг сонирхлын зөрчилгүй талаарх тодорхойлолт



ирүүлээгүй тул дараагийн шатанд оролцуулах боломжгүйг тэдгээр байгууллагуудад мэдэгдэж хассан байна.

Энэ нь Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Мөнхсайхан нь хүсэлт ирүүлээгүй "Монголын анагаах ухааны биологийн соронзон резонансын нийгэмлэг" ТББ, "Монголын хүүхдийн анагаахын академи" ТББ, "Монголын мэдрэл, толгой, хүзүүний дүрслэл оношилгооны нийгэмлэг" ТББ-ийн төлөөллийг урьдчилан сонгож, материал хүлээн авах хугацаанаас өмнө тодорхойлолт гарган өгч, бусад төрийн бус байгууллагуудад санаатайгаар саад учруулж, хариуг хүлээн авах хугацаа дууссаны дараа тодорхойлолт гаргаж өгсөн гэж үзэх үндэстэй байна.

Улмаар УНТЭ-ийн олон нийтийг төлөөлөх ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд Улсын нэгдүгээр төв эмнэлгээс тухайн эмнэлэгтэй ашиг сонирхлын зөрчилгүй талаарх тодорхойлолт гаргуулж, ирүүлэх" гэх шалгуур тавьж, шалгуурын хүрээнд нэр дэвшсэн 5 төрийн бус байгууллагад шаардлагатай хугацаанд нь тодорхойлолт гаргаж өгөхгүйгээр хасаж, урьдчилан тохиролцсон төрийн бус байгууллагуудыг шалгаруулсан байж болзошгүй байна.

Олон нийтийг төлөөлөх гишүүнд нэр дэвшигч төрийн бус байгууллагуудын хүсэлт, хариу өгсөн байдал

№	УНТЭ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд Олон нийтийг төлөөлөх гишүүнд нэр дэвшигч төрийн бус байгууллагуудын нэрс	УНТЭ-т хүсэлт өгсөн огноо	Хариу өгсөн албан бичгийн огноо
1	Монголын анагаах ухааны биологийн соронзон резонансын нийгэмлэг ТББ	Хүсэлт ирүүлээгүй	2020.01.21
2	Монголын хүүхдийн анагаахын академи ТББ	Хүсэлт ирүүлээгүй	2020.01.21
3	Монголын мэдрэл, толгой, хүзүүний дүрслэл оношилгооны нийгэмлэг ТББ	Хүсэлт ирүүлээгүй	2020.01.21
4	Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо ТББ"	2020.01.14	2020.01.22
5	Өвчтөн нийгмийн төлөөллийн зөвлөл, элэг бүтэн монгол НҮТББ"	2020.01.13	2020.01.22
6	Монголын эмнэлгийн инженерчлэлийн холбоо ТББ	2020.01.20	2020.01.27
7	Монголын мэс засалч эмч нарын холбоо ТББ	2020.01.19	2020.01.22
8	Эрүүл мэндийн чанарын менежерүүдийн холбоо ТББ	2020.01.20	2020.01.27

Эрүүл мэндийн яамнаас хүсэлт хүлээн авах өдөр 2020 оны 01 дүгээр сарын 21-нд

- Тус эмнэлгийн ТУЗ-ийн олон нийтийг төлөөлөх гишүүнд нэр дэвшсэн "Монголын мэдрэл, толгой, хүзүүний дүрслэл оношилгооны нийгэмлэг ТББ"-ын төлөөлөл Д.Тэмүүлэн нь Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ерөнхий захирлаар ажиллаж байсан Т.Мөнхсайхантай Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их сургуулийг 2006 онд хамт төгссөн олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл бүрдсэн байхад Т.Мөнхсайхан нь Д.Тэмүүлэнг ТУЗ-ын төлөөлөл болгон нэр дэвшүүлсэн "Монголын мэдрэл, толгой, хүзүүний дүрслэл оношилгооны нийгэмлэг" ТББ-д дээрх тодорхойлолтыг гаргаж өгчээ.

Учир нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.11-д "ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал" гэсэн ойлголтод хамаарах бөгөөд үүнд тухайн нийтийн албан тушаалтан өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүн гэх зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц этгээдтэй холбоотой асуудлаар үйл ажиллагаа явуулахыг" хэлдэг. Мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.6-д "Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасныг Т.Мөнхсайхан нь биелүүлээгүй

буюу энэ тухай Эрүүл мэндийн яам болон тус эмнэлгийн ТУЗ-ийг сонгон шалгаруулах ажлын хэсэгт мэдэгдээгүй байна.

Зөвлөмж 4. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ТУЗ-ийн 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 07 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Улсын нэгдүгээр төв эмнэлгийн дүрэм"-ийг хүчингүй болгох;

Эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын дүрмийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар заасны дагуу Эрүүл мэндийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн А/368 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар Улсын нэгдүгээр төв эмнэлгийн дүрмийг баталсан нь хүчин төгөлдөр байна.

Гэтэл Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 07 дугаар "Улсын нэгдүгээр төв эмнэлгийн дүрэм, бүтэц, орон тоо, стратеги төлөвлөгөө батлах тухай" тогтоолын нэгдүгээр хавсралтаар дүрмийг баталсан нь Эрүүл мэндийн тухай хуулийн 21.2-т заасныг зөрчиж байх тул хүчингүй болгох шаардлагатай.

Зөвлөмж 5. Эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг байгууллагын албан ёсны цахим хуудас болон бусад сувгаар албан хаагч, иргэдэд ил тод мэдээлэх.

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/53 дугаар тушаалаар батламжилж, Эмнэлгийн ТУЗ-ийн гишүүд Эрүүл 2020 оны 2 сараас хойш үйл ажиллагаа явуулсан байна. Үйл ажиллагаа явуулсан 2020-2021 онд Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/189, 2020 оны дугаар А/565 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн ТУЗ-д ажиллах олон нийтийн төлөөллийг сонгох журам"-ын 1.3.6-д "Сонгон шалгаруулалтын дүнг олон нийтэд мэдээлэх" гэж заасны дагуу Эмнэлгийн ТУЗ-ийг олон нийтэд болон эмнэлгийн албан хаагч нарт танилцуулаагүй, цахим хуудас болон мэдээллийн самбараар дамжуулан мэдээлээгүй байна. Ажлын хэсэг эмнэлгийн тасаг, нэгжийн эмч, албан хаагч нартай эмнэлгийн ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүнгийн талаар фокус ярилцлага хийхэд ТУЗ тус эмнэлэгт байгуулагдсан, үйл ажиллагаа явуулж байгаа талаар мэдээлэлгүй байв. Тус эмнэлгийн <http://unte.moh.gov.mn/tuz> цахим хуудасны "Төлөөлөн удирдах зөвлөл" хэсэгт нэвтрэн үзэхэд танилцуулга, бүрэлдэхүүн, үйл ажиллагаа гэх гурван цэс байх боловч ямар ч мэдээлэл байршуулаагүй байна. Ажлын хэсгийн зүгээс ТУЗ-ын үйл ажиллагаатай танилцахад тогтоол, тэмдэглэл, үйл ажиллагааны тайлан зэрэг архив албан хэрэг хөтлөлтийн үндсэн шаардлагыг хангаагүй байна. Тухайлбал, ТУЗ-ын нарийн бичгийн дарга С.Хулангийн танилцуулсан ТУЗ-ийн 2020, 2021 оны үйл ажиллагааны тайлантай танилцахад тайланг хэзээ боловсруулсан огноогүй, хэнд танилцуулсан талаарх мэдээлэлгүй албан бус тайлан байв. Эмнэлгийн албан хаагчдын фейсбүүк мэдээлэл солилцох группэд эмч, мэргэжилтнүүд эмнэлэг хэзээ ТУЗ-тэй болсон, ямар гишүүдтэй талаар мэдээлэл оруулах, эмнэлгийн удирдлагын зүгээс мэдээллээр хангахгүй байгаа талаар шүүмжилсэн сэтгэгдлүүд байна. Эндээс үзэхэд тус эмнэлгийн ТУЗ байгуулагдсанаас хойш жил гаруй хугацаанд олон нийт болон эмнэлгийн албан хаагч нарт өөрсдийн талаар болон хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг танилцуулаагүй, энэ талаар мэдээлэл ил тод бус байна.




ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зөвлөмж 6. Эмнэлгийн удирдах ажилтан, ажилтныг журамд заасны дагуу сонгон шалгаруулж ажилд томилох, цаашид сонирхлын зөрчилтэй томилгоо хийдэг явдлыг таслан зогсоох.

Эмнэлгийн удирдах ажилтан, ажилтан сонгон шалгаруулах журмын хэрэгжилт хангалтгүй, удирдах албан тушаалтнууд болон эмч, мэргэжилтэн зэрэг албан хаагчдыг сонгон шалгаруулалтгүй ажилд авдаг, ашиг сонирхлын зөрчилтэй томилгоо хийдэг зөрчил түгээмэл байна. Тухайлбал, Тус эмнэлэг 2019 онд 78 албан хаагч, 2020 онд 84 албан хаагч, 2021 оны 9 сарын байдлаар 37 албан хаагчийг сонгон шалгаруулалтгүй ажилд томилсон байна.

График 1. Сонгон шалгаруулалтгүй томилгоо



Албан хаагчдыг 2019-2021 онуудад сонгон шалгаруулалтгүй томилсон шийдвэр гаргасан этгээдийг харуулахад: Д.Чулуунбаатар 26, Т.Мөнхсайхан 93, Б.Хишигжаргал 34 иргэнийг сонгон шалгаруулалтгүй ажлын байранд томилсон байна.

			
Д.Чулуунбаатар 2019.01.01- 2019.07.05	Т.Мөнхсайхан 2019.07.05- 2020.07.10	Н.Лхажий 2020.08.18- 2021.03.01	Б.Хишигжаргал 2021.03.01-нээс
26	93	37	34

Ашиг сонирхлын зөрчилтэй томилгоо. УНТЭ-ийн ерөнхий захирлаар ажиллаж байсан Т.Мөнхсайхан нь дараах удирдах албан тушаалтнуудыг сонгон шалгаруулалтгүй, хувийн ашиг сонирхол гарган, хууль зөрчиж томилсон байна. Үүнд:

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны дарга Б.Доржханд: Тус эмнэлгийн Яаралтай тусламжийн тасгийн их эмчээр ажиллаж байсан Б.Доржхандыг Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Мөнхсайхан нь 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн Б/364 дүгээр тушаал гарган Чанар, аюулгүй байдлын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон байна. Уг томилгоог хийхдээ УНТЭ-ийн ерөнхий захирлын 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/48 дугаар тушаалаар батлагдсан "Улсын нэгдүгээр төв эмнэлгийн сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулж авах журам"-ыг баримтлан томилоогүй, Авлигатай тэмцэх газраас уг албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэх талаарх ХАСУМ гаргуулан, януулалгүйгээр шууд томилсон байна.

Тухайн томилгоог хийсэн ажил олгогч Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Мөнхсайхан нь Б.Доржхандтай 2006 онд ЭМШУУИС-ийг төгссөн нэг төгсөлтийнх бөгөөд уг томилгоог хийхэд Нийтийн албан нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3

дугаар зүйлийн 3.11, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.6-д заасныг зөрчиж ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн үед ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл, тайлбар гаргалгүйгээр томилгоо хийсэн байна.

Мөн Б.Доржханд нь 2019 оны 8 сард томилогдоход чанар, аюулгүй байдал болон удирдлагын чиглэлээр ажилласан туршлагагүй, эрдмийн болон мэргэжлийн зэрэг цолгүй, магистрын зэрэг хамгаалаагүй болох нь хувийн хэрэг болон холбогдох баримтаар нотлогдож байна. Тухайлбал, Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 565 тоот тушаалын 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн дугаар 116/А/565 тоот "Дүрэм батлах тухай" тушаалын 2.9-т "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны даргаар дараах нийтлэг шаардлага хангасан мэргэжилтэнг томилно", 2.9.2-т "Эрдмийн, эсвэл мэргэжлийн зэрэг цолтой", 2.9.3-т "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын чиглэлээр 3-аас дээш жил ажилласан туршлагатай" гэж заасныг зөрчиж, шаардлага хангахгүй хүнийг тухайн албан тушаалд томилон ажиллуулсан байна. Б.Доржханд нь 2020 оны 10 дугаар сард мэргэжлийн ахлах зэргээ хамгаалсан бөгөөд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын чиглэлээр 3-аас дээш жил ажилласан туршлагатай байх зэрэг гол шалгууруудыг хангаагүй байна.

Мөн Улсын нэгдүгээр төв Эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн "УНТЭ-ийн бүтэц, орон тоо, стратеги төлөвлөгөө батлах тухай" 07 тоот тогтоолын дагуу Чанар аюулгүй байдал дотоод хяналтын албыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын алба болгон өөрчилж, нэршил өөрчлөгдсөнтэй холбоотой тухайн албан тушаал дээр сонгон шалгаруулалтыг зарласан байна.

Бүтэц, нэршил өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны даргын сонгон шалгаруулалтыг нээлттэй, ил тод, зохион байгуулахаар 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдөр холбогдох мэдээллийг олон нийтэд байршуулж, сонгон шалгаруулалтын зарыг байршуулсан байх ба тавигдаж буй шалгуурт анагаах ухааны их дээд сургуулийг хүний их эмч мэргэжлээр төгссөн, магистр болон түүнээс дээш эрдмийн зэрэгтэй, ахлах болон түүнээс дээш мэргэжлийн зэрэгтэй, эмчлэх эрхийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх, мэргэжлээрээ 10-аас дээш жил ажилласан, удирдах албан тушаал эрхэлж байсан, эрүүл мэндийн удирдлага болон удирдахуйн ухааны чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн, хүний нөөцийн менежментийн чиглэлээр мэргэшсэн, гадаад хэлний дунд, түүнээс дээш түвшний мэдлэгтэй, зэрэг хандлагатай, багаар ажиллах манлайлах ур чадвартай байх гэсэн шаардлагыг тавьсан бөгөөд уг сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн нэр бүхий 11 иргэн материалаа ирүүлснээс зөвхөн 1 иргэн буюу Б.Доржханд эмчлэх эрхийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байсан байна. Улмаар Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Лхажий 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн Б/584 дугаар тушаалаар Б.Доржхандыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны даргын албан тушаалд томилсон байна.

Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.20-д "эмнэлгийн бусад мэргэжилтэн" гэж анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллеж төгссөн, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шаардагдахгүй бусад мэргэжилтнийг" гэж тусгайлан заасан байхад Захиргаа, хүний нөөцийн албаны дарга болон Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны даргын албан тушаалд тавигдах шаардлагад "эмчлэх эрхийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх" гэсэн нэмэлт шаардлагыг тавьсан нь сонгон шалгаруулалтад оролцсон бусад иргэдийн сонгогдох боломжийг хязгаарлах, Б.Доржхандад давуу байдал олгох зорилгыг агуулсан байж болзошгүй байна.

Нэр төдий сонгон шалгаруулалт хийсэн тухайн асуудлыг Авлигатай тэмцэх газраас 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 05/8878 дугаартай "Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай" албан бичгээр зөрчил арилгуулах даалгаврыг тус эмнэлгийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Хишигжаргалд хүргүүлсэн ч одоог хүртэл арга хэмжээ аваагүй, хариу ирүүлээгүй байна.

Захиргаа, хүний нөөцийн албаны дарга П.Анхтүяа: П.Анхтүяа нь тухайн албан тушаалд томилогдохдоо өөртөө давуу байдал үүсгэн ажлын байранд тавигдах шаардлагыг өөртөө тааруулан зарлаж, бусдыг оролцох боломжоор хангаагүй байна. УНТЭ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 07 дугаар тогтоолоор УНТЭ-ийн дүрэм, бүтэц, орон тоо, стратеги төлөвлөгөөг шинэчлэн баталж, тус

эмнэлгийн Хүний нөөц, хөгжлийн албаны нэршил, чиг үүрэгт өөрчлөлт орж, Захиргаа, хүний нөөцийн алба болсон байна. Энэ үндэслэлээр Хүний нөөц, хөгжлийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Анхтуяаг Захиргаа, хүний нөөцийн албаны даргын албан тушаалд сонгон шалгаруулалт зарлах хүртэл хугацаагаар түр томилсон байна. "УНТЭ-ийн удирдах ажилтан, ажилтан сонгон шалгаруулах журам"-д зааснаар сонгон шалгаруулалтын комисс нь шалгаруулалтын товыг тогтоож, сонгон шалгаруулалтыг журмын дагуу зохион байгуулах, удирдан зохион байгуулах эрх, үүрэгтэй ба "Удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалт нь "баримт бичгийн үнэлгээ, "шалгалт авах, "ярилцлага, салбарын хөгжлийг тодорхойлох төсөл хөтөлбөрийн талаарх танилцуулга хийх, сонгон шалгаруулалтын нэгдсэн үнэлгээ хийх, үнэлгээний дүнг хэлэлцэх, шийдвэр гаргах, үнэлгээний дүнг нэр дэвшигчдэд мэдээлэх, эрх бүхий албан тушаалтанд танилцуулах, гэрээ хийж хамт олонд танилцуулах" гэсэн 7 үе шаттай явагдахаар заажээ.

Гэтэл УНТЭ-ийн Захиргаа, хүний нөөцийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Анхтуяа нь тус эмнэлгийн захирал асан Н.Лхажийгаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу сонгон шалгаруулалтын зар боловсруулахыг мэргэжилтэн О.Лхагвасүрэнд үүрэг болгосон, улмаар зарыг хянахдаа УНТЭ-ийн Ерөнхий захирлын 2013 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 603 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан "Хүний нөөц, хөгжлийн албаны даргын ажлын байрны тодорхойлолт"-ын албан тушаалд тавигдах шаардлагыг өөрт тохируулан өөрчилсөн болох нь АТГ-ын удаа дараагийн шалгалтаар нотлогдож байсан. Мөн П.Анхтуяа нь сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн ажил горилогчдын ирүүлсэн материалд баримт бичгийн үнэлгээг өөрөө хийж, шалгалтын тестийг урьдчилан авч, хоёр дахь шатны шалгаруулалтад ганцаараа орж, тэнцэн, улмаар УНТЭ-ийн Ерөнхий захирлын 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн Б/654 дугаартай тушаалаар Захиргаа, хүний нөөцийн албаны даргаар томилогдсон нь бичгийн нотлох баримт болон албан тушаалтнуудын тайлбараар тогтоогдсон.

Санхүү бүртгэлийн албаны дарга Б.Банзрагч: УНТЭ-ийн Санхүү бүртгэлийн албаны орлогч нягтлан бодогч Б.Банзрагчийг Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Мөнхсайхан нь 2019 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн Б/5410 дугаар тушаалаар Санхүү бүртгэлийн албаны дарга, шилэн данс хариуцсан нягтлан бодогчийн ажлыг хавсран гүйцэтгэх, 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн Б/40 дугаар тушаалаар Санхүү бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогчоор тус тус томилсон байна. Уг томилгоог хийхэд УНТЭ-ийн ерөнхий захирлын 2017 оны 02 дугаар сарын 17-ний өдрийн А/48 дугаар тушаалаар баталсан "Улсын нэгдүгээр төв эмнэлгийн сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулж авах журам"-ыг баримтлан томилоогүй, сонгон шалгаруулалтгүй шууд томилсон байна. Мөн Б.Банзрагч нь Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, тэдгээрийн эрх, үүрэг, ажилд томилох, чөлөөлөх журам"-ын 2.1.3-т "Төсвийн ерөнхий нягтлан бодогч нь ахлах нягтлан бодогч буюу нягтлан бодогчоор 7-оос доошгүй жил, үүнээс төвлөрүүлэн болон шууд захирагчийн ахлах нягтлан бодогчийн ажлыг 5-аас доошгүй жил эсвэл санхүү, төрийн сангийн газар, хэлтэст 3-аас доошгүй жил ажилласан, эрх бүхий мэргэшсэн нягтлан бодогч зэрэгтэй байх" гэсэн шаардлага, шалгуурыг хангахгүй буюу ахлах нягтлан бодогчоор 2 жил ажилласан, мэргэшсэн нягтлан бодогчийн эрх аваагүй этгээдийг томилсон байна.

Төлөвлөлт, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал Б.Түвшинтөр:

УНТЭ-ийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байхдаа Т.Мөнхсайхан нь 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн Б/351 дүгээр тушаалаар Аж ахуй, үйлчилгээний албаны даргын албан тушаалд Б.Түвшинтөрийг сонгон шалгаруулалтгүй шууд томилсон байна. Үүний дараа эмнэлгийн ерөнхий захирал Н.Лхажий нь 2020 оны 09 дүгээр сарын Б/496 дугаар тушаалаар Б.Түвшинтөрийг эмнэлгийн Төлөвлөлт, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирлын албан тушаалд томилж, УНТЭ-ийн ТУЗ-ийн 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 11 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Удирдах ажилтан, ажилтан сонгон шалгаруулах журам"-ыг баримтлалгүйгээр уг ажлын байранд сонгон шалгаруулалт зохион байгуулалгүйгээр шууд томилсон байна. Мөн Б.Түвшинтөр нь өмнө нь Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ-т 2016-2019 онд Захиргаа, хүний нөөцийн албаны даргаар ажиллаж байсан ба тус эмнэлэгт одоо ажиллаж байгаа Эдийн засаг, маркетингийн албаны эдийн засагч Э.Ганзориг, Захиргаа, хүний нөөцийн албаны хуулийн зөвлөх Б.Тэлмэн нартай дээрх

байгууллагад хамт ажиллаж байсан байна. Б.Түвшинтөр нь хамт ажиллаж байсан Э.Ганзориг, Б.Тэлмэн нарыг ажилд сонгон шалгаруулалтгүй авсан гэх үндэслэлтэй байгааг доорх хүснэгтэн дэх мэдээлэл харуулж байна:

Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ-т ажиллаж байсан мэдээлэл		
Б.Түвшинтөр	Б.Тэлмэн	Э.Ганзориг
2016-2019.08.04	2018-2019.11.18	2017-2019.12.16
Захиргаа хүний нөөцийн албаны даргаар ажиллаж байсан	Хүний нөөцийн мэргэжилтнээр ажиллаж байсан	Бичиг хэрэг, төлөвлөлтийн мэргэжилтнээр ажиллаж байсан
одоо УНТЭ-т Төлөвлөлт, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал	одоо УНТЭ-т Захиргаа, хүний нөөцийн албаны хуулийн зөвлөх	одоо УНТЭ-т Эдийн засаг, маркетингийн албаны эдийн засагч

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11-д заасан олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдлыг үүсгэсэн байна.

Сонгон шалгаруулалтад ороогүй томилогдсон Б.Түвшинтөрийг Төлөвлөлт, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирлын албан тушаалд томилоход ажлын байрны тодорхойлолтыг Б.Тэлмэн (өөртэй нь хамт Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ-т ажиллаж байсан) боловсруулж, ингэхдээ Б.Түвшинтөрийн боловсрол эзэмшсэн байдал, ажлын туршлагад нийцүүлэн боловсруулсан байж болзошгүй байна. Тухайлбал, ажлын байранд тавигдах тусгай шаардлага хэсэгт "их дээд сургуулийн магистр болон түүнээс дээш зэрэг төгссөн, эрх зүйч, эдийн засаг, маркетингийн чиглэлээр мэргэжил эзэмшсэн, Англи хэлний зохих түвшний мэдлэгтэй байх" гэх зэргээр хэт ерөнхий шаардлага тусгасан. Улсын хэмжээний 3 дугаар шатлалын нэгдсэн төв эмнэлгийн төлөвлөлт, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирлын ажлын байранд эрүүл мэндийн салбарт ажилласан туршлага, эрдмийн зэрэг дэвд тавигдах шаардлага, гадаад хэлний мэдлэгийн түвшинг тодорхой зааж өгөөгүй байна.

Сургалт, эрдэм шинжилгээ, инновац эрхэлсэн дэд захирал, сургалт, эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааны албаны дарга Б.Нинжбадгар:

УНТЭ-ийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байхдаа Т.Мөнхсайхан 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн Б/540 дугаар тушаалаар Б.Нинжбадгарыг тус эмнэлгийн Сургалт, эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааны албаны даргын албан тушаалд сонгон шалгаруулалтгүй томилсон байна. Б.Нинжбадгар нь эрдмийн зэрэг цолгүй, магистр, докторын зэрэг дэвгүй, удирдах албан тушаал өмнө хашиж байгаагүй, ажлын байранд тавигдах шаардлагад тэнцэхгүй этгээдийг томилсон байна.

Захиргаа, хүний нөөцийн албаны ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, бичиг хэргийн эрхлэгч С.Хулан:

УНТЭ-ийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Мөнхсайхан 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн Б/123 дугаар тушаалаар С.Хуланг Захиргаа, хүний нөөцийн албаны ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, бичиг хэргийн эрхлэгчийн албан тушаалд сонгон шалгаруулалтгүй томилсон байна.

Ажлын хэсэг удирдамжид заасны дагуу 2019-2021 онуудад хүний нөөцийн бодлого хэрэгжилт, албан тушаалд томилогдсон байдалд дүгнэлт хийхэд хүний нөөцийн тогтвортой байдал хангалтгүй, албан тушаалтнуудыг хууль бусаар ажил албан тушаалаас чөлөөлөх, ажлын байранд сонгон шалгаруулалт хийлгүйгээр иргэнийг томилох, ажлын байрны тодорхойлолт, албан тушаалд тавигдах шаардлагыг хувь хүнд тохируулан боловсруулж, бусдын эрхийг хязгаарлах, нэр төдий сонгон шалгаруулалт зохион байгуулах, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц томилгоо хийх зэрэг зөрчил түгээмэл байгаа нь харагдаж байна. Тухайлбал, тус эмнэлэг 2019-2021 онд 434 ажлын байранд сонгон шалгаруулалт зохион байгуулж, 199 ажлын байранд сонгон шалгаруулалт зарлалгүйгээр шууд томилсон. Эмнэлгийн дэд захирал, чанар аюулгүй байдал, хүний нөөц, аж ахуйн алба гэх зэрэг удирдах албан тушаалын ажлын байруудад 2019 оноос хойш сонгон шалгаруулалтыг нэр төдий зохион байгуулсан, сонгон шалгаруулалтгүй томилсон зэрэг авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчил түгээмэл гарсан байна.

Захиргаа, хүний нөөцийн албаны хуулийн зөвлөх Б.Тэлмэн:

Б.Тэлмэн нь Төлөвлөлт, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал Б.Түвшинтөртэй 2018-2019 онуудад Улаанбаатар зам, засвар арчлалтын газар ОНӨААТҮГ-т ажиллаж байсан бөгөөд Б.Түвшинтөрийн УНТЭ-т аж ахуйн албаны даргын ажилд томилогдсоноос хойш 3 сарын дараа УНТЭ-ийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Мөнхсайхантай 2019 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн ХӨ10/19 дугаартай "Хөлсөөр ажиллах гэрээ"-г хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор нэг жилийн хугацаатай байгуулсан байна. Уг гэрээний хугацаа дуусаагүй байхад УНТЭ-ийн бүтэц орон тоо шинэчлэх ажил зохион байгуулан, УНТЭ-ийн ерөнхий захирал Н.Лхажийгийн 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/390 дугаар тушаалаар Б.Тэлмэнг Захиргаа, хүний нөөцийн албаны хуулийн зөвлөх ажлын байрыг шинээр байгуулан сонгон шалгаруулалтгүй томилсон байна. Б.Тэлмэнтэй анх хөлсөөр ажиллах гэрээ байгуулах болон Захиргаа, хүний нөөцийн албаны хуулийн зөвлөх ажлын байранд сонгон шалгаруулалт хийгээгүй шууд томилсон. Мөн Б.Түвшинтөртэй өмнө нь хамт ажиллаж байсан зэрэг нь олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсгэсэн байна.

Зөвлөмж 7. Албан хаагчдын нийгмийн асуудлыг хүний нөөцийн бодлогын баримт бичиг болон холбогдох судалгаанд үндэслэн шударга, ил тод, нээлттэй байдлаар шийдвэрлэх.

Засгийн газрын 2019 оны 138 дугаар тогтоолын дагуу тус эмнэлэгт түрээслээд өмчлөх орон сууцны хөтөлбөрт хамрагдах 46 орон сууцны эрхийг 2020 оны 04 дүгээр сард олгосон байна. Түрээслээд өмчлөх орон сууцны эрх авсан 46 ажилтныг судлан үзэхэд тус эмнэлэгт 1 сар ажилласан шинэ ажилтнаас эхлээд 33 жил ажилласан туршлагатай эмч, мэргэжилтэн, албан хаагчид ч байна. Хамгийн бага хугацаанд тус эмнэлэгт ажилласан нь ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, бичиг хэргийн эрхлэгч С.Хулан бөгөөд 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн Б/123 дугаар тушаалаар ажилд томилогдоод нэг сар ажиллаж байхад нь түрээслээд өмчлөх орон сууцны эрх олгосон байна.

Мөн тус эмнэлэгт 2019 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр "Хөлсөөр ажиллах гэрээ"-г нэг жилийн хугацаатай байгуулан, хуульчаар 5 сар ажиллаж байсан, эмнэлгийн үндсэн ажилтан бус Б.Тэлмэнд уг орон сууцны эрхийг олгосон байна.

Түүнчлэн ажилд ороод 4 сар болж байсан, өмнө нь ажил эрхэлж байгаагүй, тухайн үед тус эмнэлгийн ерөнхий захирлаар ажиллаж байсан Т.Мөнхсайханы жолооч О.Басбаярт түрээслээд өмчлөх орон сууцны эрх олгосон байна. О.Басбаяр нь Т.Мөнхсайханыг Эрүүл мэндийн сайдын албан тушаалд томилогдмогц Эрүүл мэндийн яаманд жолоочоор ажилд орсон байна.

Гэтэл хамгийн сүүлд буюу 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар гаргасан УНТЭ-ийн "Түрээсийн орон сууцанд хамрагдах хүсэлтэй Эрүүл мэндийн ажилтны судалгаа"-аас харахад төрд хамгийн олон жил ажилласан буюу улсад 40 жил, УНТЭ-т 35 жил ажилласан Инженер байгууламжийн албаны Сантехникийн цэвэр бохирын слесарь Д.Лувсандорж зэрэг орон сууцгүй олон ажилтнууд уг эрхийг авч чадаагүй байна.

Өөрөөр хэлбэл, түрээслээд өмчлөх орон сууцны эрхийг ажилтнуудын ажилласан жил, нийгмийн баталгаа, амьжиргааны түвшин зэргийг харгалзахгүйгээр шийдвэрлэсэн байна.

Тус эмнэлэг нь одоогоор 824 орон тоотой бөгөөд үүнээс 30-аас дээш жил ажилласан 56, 21-30 ажилласан 160, 6-10 жил ажилласан 158, 5 хүртэлх жил ажилласан 256 албан хаагч байна. Үүнээс харахад тус эмнэлэгт 5-аас дээш жил ажилласан "Түрээсийн орон сууцанд хамрагдах хүсэлтэй эрүүл мэндийн ажилтны судалгаа"-нд хамрагдсан 491 албан хаагч байна. Эмнэлгийн удирдлагаас түрээслээд өмчлөх орон сууцны эрхийг шударгаар, ил тод нээлттэй байдлаар хуваарилах ажлыг зохион байгуулаагүй гэж үзэхээр байна.

Тухайлбал, түрээслээд өмчлөх орон сууцны эрх олгох үйл ажиллагааг тус эмнэлгээс 2019 онд хийсэн "УНТЭ-ийн ажилчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд авах ерөнхий суурь судалгаа"-г ашиглаж зохион байгуулаагүй, эмнэлгийн тасаг нэгж, албадад ил тодоор мэдээлж, зарлал хүргээгүй, албан хаагч нараас санал авах ажлыг зохион байгуулалгүйгээр удирдлагын түвшинд шийдвэрлэсэн байна. Тухайн үед Хүний нөөцийн албаны даргаар ажиллаж байсан А.Солонго ажлын хэсгийг ахалж байсан бөгөөд түрээслээд өмчлөх орон сууцны эрхийг өөртөө олгосон байж байгаад эмнэлгийн албан хаагч нар эсэргүүцэж, шүүмжлэлтэй хандсан тул түрээслээд өмчлөх орон сууцны эрхийг буцаасан байна.

ГУРАВ ДУГААР ХЭСЭГ. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Зөвлөмж 8. Худалдан авах ажиллагааны чиглэлээр зохих сургалтад хамрагдаж, АЗ сертификат аваагүй этгээдийг тендерийн үнэлгээний хороонд ажиллуулсан зөрчил болон үнэлгээний хорооны гишүүдэд цөөн тооны ажилтнууд олон удаагийн давтамжтай томилогдон худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгааг тус тус таслан зогсоох, худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн албан хаагчдын тоог нэмэгдүүлэх, тэднийг сургах, чадавхжуулах.

Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь 2021 оны байдлаар нийт 869 ажилтантай бөгөөд худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдсан нийт 29 ажилтан байх ба үүнээс 2019 онд 12, 2020 онд 3, 2021 онд 9 ажилтан сургалтад хамрагдаж, АЗ гэрчилгээ авсан байна.


Тус эмнэлгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах тендерийн үнэлгээний хороонд 2019 онд эмнэлгийн 25, хөндлөнгийн 11, 2020 онд эмнэлгийн 22, хөндлөнгийн 7, 2021 онд эмнэлгийн 20, хөндлөнгийн 5 ажилтан тухай бүр томилогдон ажилласан байна.

2019-2021 онд Ц.Амаржаргал, С.Батцэнгэл, Г.Баяр, Б.Түвшинтөр, Э.Ганзориг, Б.Бат-Ирээдүй, С.Учрал, Б.Хишигжаргал, Д.Далайжаргал, П.Ганчимэг, Л.Хэрлэнчимэг, С.Алтансүх, Ц.Сэржмядаг, С.Уянга нар хамгийн их давтамжтайгаар орсон байна.

Гэтэл Д.Чулуунбаатар, О.Сэргэлэн нар АЗ гэрчилгээтэй боловч нэг ч удаа Тендерийн үнэлгээний хороонд томилогдон ажиллаагүй байна.

Тендерийн үнэлгээний хороонд томилогдсон байдлыг 2019, 2020, 2021 онд эмнэлгийн ажилтнуудын нэрээр графикаар харуулбал:

График 2. Үнэлгээний хороонд орсон гишүүдийн харьцуулалт



Худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдаагүй болон гэрчилгээний хугацаа дууссан ажилтнуудыг үнэлгээний хорооны гишүүн, даргаар томилж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар 47.6-д "Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна." гэж заасныг зөрчсөн байна. Тухайлбал,

2019 онд Инженерийн байгууламжийн албаны дарга Г.Цэрэнбадам АЗ гэрчилгээ байхгүй атлаа Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ерөнхий захирлын 2019 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/264 дүгээр тушаалаар үнэлгээний хорооны гишүүнээр;

2020 онд Зүрхний төвийн дарга Д.Эрдэмбилэг АЗ гэрчилгээ байхгүй атлаа Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ерөнхий захирлын 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/394 дүгээр тушаалаар үнэлгээний хорооны гишүүнээр;

2021 онд Бөөрний төвийн дарга Д.Чулуунцэцэгийн АЗ гэрчилгээний хугацаа 2020 оны 11 дугаар сарын 17-ны өдөр, Эмзүйн албаны эм найруулагч Г.Туяагийн гэрчилгээний хугацаа 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдөр тус тус дууссан, Зүрхний төвийн дарга

Д.Эрдэмбилэг АЗ гэрчилгээгүй байхад Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ерөнхий захирлын 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/01 дугаартай тушаал, 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/04 дугаартай тушаалаар үнэлгээний хорооны гишүүнээр тус тус томилогдож, төлбөрийг төр хариуцах эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис худалдан авах, Эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж худалдан авах, Угаалга, хоол үйлдвэрлэл, Харуулын үйлчилгээний ажил худалдан авах, Диализ эмчилгээний ажил гүйцэтгэх гүйцэтгэгч сонгон шалгаруулах зэрэг тендерийг зохион байгуулах бүрэлдэхүүнд томилогдон, оролцож ажилласан байна.

Зөвлөмж 9. Хуульд заасны дагуу нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулалгүй шууд худалдан авалт хийх, нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж, хэд хэдэн тендер шалгаруулалт зохион байгуулах, үнийн санал авах нэрээр шууд худалдан авалт хийх болон нэмэлт гэрээ байгуулахтай холбоотой зөрчлийг таслан зогсоож, дахин энэ төрлийн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж ажиллах.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ." гэж заасан бөгөөд Засгийн газраас "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдөр хүртэл 10 сая төгрөгөөр, түүнээс хойш 20 сая төгрөгөөр тогтоосон байна. *(Засгийн газрын 2013 оны 68, 2021 оны 124 дүгээр тогтоол)*

Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу тендер шалгаруулалт зарлалгүй шууд худалдан авалт хийсэн зөрчлийг удаа дараа гаргасан байна.

Тухайлбал, "Баянсоёмбо" ХХК-тай 2019-2021 оны хооронд "Харуул хамгаалалтын гэрээ"-ний дагуу нийт 2019 онд 52,566,000, 2020 онд 59,753,950, 2021 оны 09 дүгээр сарын байдлаар 35,653,600, нийт 147,973,550 төгрөг шилжүүлсэн байна. Эмнэлгийн зүгээс 2019-2021 онуудад нийт 6 удаа гэрээ байгуулсан байх боловч холбогдох хуульд заасны дагуу нээлттэй сонгон шалгаруулалтын журмаар худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна. УНТЭ-ийн ерөнхий захирлын 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/01 дүгээр "Угаалга, хоол үйлдвэрлэл, харуулын үйлчилгээний ажил худалдан авах тухай тендерийн үнэлгээний хороо байгуулах тухай" тушаалаар үнэлгээний хороог байгуулсан боловч tender.gov.mn цахим хуудсанд 2021 оны 04 дүгээр 01-ний өдөр зөвхөн "Тусламж үйлчилгээний хоол үйлдвэрлэл гүйцэтгэх тендер" зарлагдаж, угаалга болон харуул, хамгаалалтын үйлчилгээний тендер зарлагдаагүй байна.

- "Төгс гэрэлт цамхаг" ХХК-тай 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр УНТЭ193/20 дугаартай 61,688,954 төгрөгийн дүнтэй "Эрүүл мэндийн дэмжих төвийн ерөөний рентген хамгаалалт, Дүрс оношилгооны төвийн шатны хонгилын засвар, дөрвөн давхрын хурлын заалны ерөөний засварын ажил гүйцэтгэх гэрээ" байгуулсан байна. Мөн тус компанитай 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдөр УНТЭ28/21 дугаартай 23,002,786 төгрөгийн дүнтэй "Ковид цар тахлыг оношилж, шинжилгээ хийх PCR лаборатори байгуулах хэсгийн засварын ажил гүйцэтгэх гэрээ" байгуулсан байна. Тус гэрээнүүдийн 1.2-т "Энэхүү гэрээг УНТЭ-ийн захирлын 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/395 дугаар тушаалаар томилогдсон тендерийн үнэлгээний хорооны 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн байгуулав." гэсэн байх ба УНТЭ-ийн Ерөнхий захирлын 2020 оны А/395 дугаар тушаалаар "2020 оны эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн засвар үйлчилгээний ажил худалдан авах тендерийн үнэлгээний хороо"-г байгуулсан байна. Гэтэл төрийн худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системд тус тендер зарлагдаагүй байх ба энэ нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ороогүй, цахим системээр зарлагдаагүй, шууд худалдан авалт хийсэн гэж үзэхээр байна.

- "Ирмүүн бар" ХХК-тай 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдөр УНТЭ113/21 дугаартай 59,752,505 төгрөгийн дүнтэй "Гастроэнтрологи, Амбулатори 4 давхар, Урологийн төвийн 3 ариун цэврийн ерөөний засварын ажил гүйцэтгэх гэрээ" байгуулсан байна. Гэрээний 1.2-т "Энэхүү гэрээг УНТЭ-ийн захирлын 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/56 дугаар тушаалаар томилогдсон тендерийн үнэлгээний хорооны 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн байгуулав." гэсэн байх ба УНТЭ-ийн Ерөнхий

захирлын 2021 оны А/56 дугаар тушаалаар "2021 оны эмнэлгийн засвар үйлчилгээний ажил худалдан авах тендерийн үнэлгээний хороо"-г байгуулсан байна. Энэ тендер нь мөн худалдан авах ажиллагааны цахим системд байхгүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ороогүй, цахим системээр зарлагдаагүй, шууд худалдан авалт хийгдсэн гэж үзэхээр байна.

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-т "Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно.", Засгийн газрын 2013 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 68 дугаар "Босго үнэ шинэчлэн батлах тухай" тогтоолын хавсралтаар харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг барааг 50 сая, ажлыг 80 сая төгрөгөөр тус тус тогтоосон байна. УНТЭ-ийн шилэн дансны мэдээллээс 2020 оны худалдан авах ажиллагааны тайланг² үзэхэд нийт 588 худалдан авах ажиллагааны мэдээллийг оруулсан байгаагаас дараах 10 барааг худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.2-т заасныг зөрчсөн байж болзошгүй, 50 сая төгрөгөөс дээш үнэтэй барааг худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулах аргаар зохион байгуулаагүй, тус хуулийн 33.2.2 дахь заалтыг үндэслэн харьцуулалтын аргаар зохион байгуулсан гэж тайлагнасан байна. Үүнд:

№	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Гэрээний дүн	Гүйцэтгэгчийн нэр, гэрээний дугаар
1	Эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авах	72 245 750	Айвико интернэйшнл ХХК
2	Үндсэн үйл ажиллагаанд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах гэрээ байгуулах тухай	131,722,300	Айвико Интернэйшнл ХХК
3	Үндсэн үйл ажиллагаанд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах гэрээ байгуулах тухай	52,528,537	Монос Трейд ХХК
4	Үндсэн үйл ажиллагаанд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах гэрээ байгуулах тухай	58,200,100	Нахиа Импекс ХХК
5	Үндсэн үйл ажиллагаанд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах гэрээ байгуулах тухай	78,300,000	Монгол Фарм ХХК
6	Хэвлийн ЭХО аппарат	109,285,000	Шинжьюку ХХК
7	Үндсэн үйл ажиллагаанд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах гэрээ байгуулах тухай	116,157,000	Мөнхийн тун ХХК
8	Үндсэн үйл ажиллагаанд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах гэрээ байгуулах тухай	88,880,000	Аксис систем
9	Үндсэн үйл ажиллагаанд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах	73,806,550	Айвико Интернэйшнл ХХК
10	Үндсэн үйл ажиллагаанд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах	72,885,750	Айвико Интернэйшнл ХХК

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно." гэж заасан байна. Тухайлбал, тус эмнэлгээс 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдөр УНТЭ/166/20, УНТЭ 167/20 дугааруудтай гэрээг "Нэкст Элетроникс" ХХК-тай Дотрын нэгдсэн тасгийн Вип тасагт хөргөгч 7,917,800, зурагт 9,098,700 төгрөгөөр худалдан авахаар худалдах, худалдан авах гэрээ байгуулсан байна. Уг хоёр барааг нэг байгууллагаас Дотрын нэгдсэн тасгийн Вип

² <https://shilendans.gov.mn/org/1284?form=4589089&year=2020&month=12&group=1&task=4060> УНТЭ-ийн 2020 оны худалдан авах ажиллагааны тайлан

тасагт зориулан шууд худалдан авсан байх ба нийт үнийн дүн 17,016,500 болохоор байна. Энэ нь нээлттэй тендер зарлахаар байхад шууд худалдан авах босго үнэд багтаах зорилгоор хуваасан гэж үзэхээр байна.

-Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4.-т "нэмэлт ажлын өртөг нь анхны гэрээний үнийн 15 хувь болон энэ хуулийн 8.1.1-д заасан харьцуулалтын босго үнийн аль багаас хэтрээгүй нөхцөлд тендер шалгаруулалтаар худалдан авсан ажлын нэмэлт болон түүнтэй ижил төстэй ажлыг давтан хийх тохиолдолд дахин тендер шалгаруулалт явуулснаар илүү сайн санал ирэхгүй гэж үзсэн бол," гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэж болно гэж заасан. Гэтэл УНТЭ нь 2020 оны 07 дугаар сард УНТЭ/202005041 тендер шалгаруулалтын дугаартай 190,000,000 сая төгрөгийн төсөвтэй "Зүүн байрны 6 давхрын засварын ажил гүйцэтгэх гэрээ гэрээ"-г "Ирмүүн бар"ХХК-тай байгуулсан байх ба үүний дараа 2021.12.01-ний өдөр дахин 34,962,405 төгрөгийн дүнтэй "Зүүн байрны 6 давхрын засварын ажил гүйцэтгэх гэрээ"-г нэмэлт ажлын гэрээ гэх байдлаар байгуулсан байна. Нэмэлт ажлын гэрээг шууд байгуулж буй тохиолдолд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.1.4.-т заасан анхны гэрээний үнийн дүн болох 190 сая төгрөгийн 15 хувь буюу 28,500,000 төгрөгөөс хэтрүүлэхгүй дүнгээр гэрээ байгуулж байгуулах байхад 34,962,405 төгрөгөөр гэрээ байгуулж, хууль зөрчсөн байна.

Зөвлөмж 10. Тендерийн бичиг баримтын бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтан, үнэлгээний хорооны гишүүдийн ёс зүй, хариуцлагыг чангатгах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д "Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална" гэсэн хуулийн заалтын хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал, тус эмнэлгийн худалдан авах ажиллагааны материалтай танилцахад 2019, 2020 оны материал архивлагдаагүй, бичиг хэргийн хадгалалт, хамгаалалтын байдал хангалтгүй, хариуцсан ажилтнууд худалдан авах ажиллагааг хувааж танилцуулсан, нэгдсэн жагсаалт, мэдээлэл тодорхойгүй, эмх замбараагүй, эх хувь, хуулбарласан материалууд холилдсон, тендерийн баримт бичиг боловсруулалт хангалтгүй байв. Мөн Төрийн худалдан авах ажиллагааны газрын tender.gov.mn цахим системээс 2021 оны Тендер шалгаруулалтын УНТЭ/202103006 дугаартай "Өндөр өртөгт эмнэлгийн хэрэгсэл" тендерийн баримт бичгийг түүврийн аргаар сонгон судалж үзэхэд тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт болон тендерийн урилга дахь мэдээллүүд зөрүүтэй байна. Тухайлбал,

№	Асуулга	Тендерийн баримт бичиг	Тендерийн урилга	Тайлбар
1	Тусгай зөвшөөрөл	Тусгаагүй	Тусгасан	Тендерийн баримт бичигт тусгай зөвшөөрлийн мэдээллийг багц тус бүрээр тусгаагүй, тендерийн урилгад тусгасан.
2	Багцын мэдээлэл	104	108	Багцын мэдээлэл зөрүүтэй, тендерийн баримт бичигт багцын мэдээллийг тусгаагүй.
3	Техникийн тодорхойлолт	Байхгүй		Техникийн тодорхойлолтыг тендерийн баримт бичигт тусгаагүй. Тодруулгаар зарим багцын техникийн тодорхойлолтыг оруулсан.
4	Тендерийн үр дүн			Тендерт нийт 83 багцад компани шалгарсан мэдээллийг оруулсан.

Тендерийн багцын мэдээлэл, тусгай зөвшөөрөл, техникийн тодорхойлолтыг тусгалгүй сонгон шалгаруулалт зарлаж буй нь тендерийн баримт бичгийн боловсруулалт маш хангалтгүй байгааг харуулж байна. Эдгээр нь тендерт оролцогчдод тодорхойгүй нөхцөл байдлыг бий болгон авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй байна.

Зөвлөмж 11. Төлбөрийг төр даах эм, эмнэлгийн хэрэгсэл болон өндөр өртөгт эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ажиллагаанд цөөн тооны байгууллагуудтай он дараалан гэрээ байгуулж байгаа нь авлига, ашиг сонирхлыг зөрчил үүсэх эрсдэл үүсгэж байгааг анхаарч, худалдан авах ажиллагааны журмыг чанд мөрдөж ажиллах.

Тус эмнэлгийн хувьд өндөр өртөгтэй эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа дээрх 15 компанийг 3 он дараалан сонгон шалгаруулсан, төлбөрийг төр хариуцах эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа нэр бүхий 17 компанийг 3 он дараалан сонгон шалгаруулж, их хэмжээний хөрөнгө шилжүүлсэн, мөн тендерийн баримт бичгийн боловсруулалт хангалтгүй, цахим системд зарлагдсан тендерийн үр дүнг бүрэн дүүрэн оруулдаггүй байдал нь авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг харуулж байна.

А. Өндөр өртөгт эмнэлгийн хэрэгсэл худалдан авах гэрээ байгуулсан байгууллагууд руу гэрээ байгуулж, төлбөр шилжүүлсэн тоо, мөнгөн дүнг дансны хуулганаас түүвэрлэн авч үзүүлбэл:

№	Он	Өндөр өртөгт эмнэлгийн хэрэгслийн үнэ гүйлгээний тоо	Өндөр өртөгт эмнэлгийн хэрэгслийн үнийн дүн	Харилцсан компанийн тоо
1	2019	184	4,285,848,962	23
2	2020	147	7,691,856,582	24
3	2021.09	82	3,951,517,855	24

Улсын нэгдүгээр төв эмнэлэгт 2019-2021 оны хооронд өндөр өртөгтэй эмнэлгийн хэрэгсэл худалдан авах гэрээ байгуулсны дагуу нийт 32 компанид 413 удаагийн гүйлгээгээр 15.9 тэрбум төгрөг шилжүүлсэн байна. Үүнээс дараах 15 компанийг 3 жил дараалан шалгаруулсан байх ба эдгээр 15 компанид өндөр өртөгтэй хэрэгсэл худалдан авах гэрээний дагуу 3 жилийн хугацаанд шилжүүлсэн үнийн дүнг үзүүлбэл:




Эдгээр 15 компаниас өндөр өртөгтэй эмнэлгийн хэрэгсэл худалдан авах гэрээний дагуу "Эндоженмонголиа" ХХК-д нийт 3,6 тэрбум төгрөг, "МедМонгол" ХХК-д 2,2 тэрбум, "Санчир Ундрах" ХХК-д 1,5 тэрбум төгрөгийг 2019-2021 онуудад шилжүүлсэн нь хамгийн өндөр дүнг эзэлж байна.

Б. Төлбөрийг төр даах эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах гэрээ байгуулсан байгууллагууд руу төлбөр шилжүүлсэн тоо, мөнгөн дүнг дансны хуулганаас түүвэрлэн авч үзүүлбэл:

№	Он	Төлбөрийг төр даах эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ шилжүүлсэн гүйлгээний тоо	Төр даах эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн дүн	Харилцсан компанийн тоо
1	2019	208	5,744,562,461	26
2	2020	144	5,972,667,678	29
3	2021.09	69	2,475,388,667	24

Улсын нэгдүгээр төв эмнэлэгт 2019-2021 оны хооронд төр хариуцах эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах гэрээ байгуулсны дагуу нийт 36 компанид 421 удаагийн гүйлгээгээр 14,2 тэрбум төгрөг шилжүүлсэн байна. Үүнээс дараах 17 компани 3 жил дараалан шалгарсан байх ба эдгээр 17 компанид төр хариуцах эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах гэрээний дагуу шилжүүлсэн 3 жилийн хугацааны үнийн дүнг үзүүлбэл:



Эдгээр 17 компаниас төр хариуцах эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах гэрээний дагуу Айвико интернэшнл ХХК-д нийт 5,0 тэрбум төгрөг, Монос Фарм трейд ХХК-д 1,5 тэрбум, Азифарма ХХК-д 1,3 тэрбум төгрөгийг 2019-2021 онуудад шилжүүлсэн нь хамгийн өндөр дүнг эзэлж байна.

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ. ХАНДИВ ТУСЛАМЖ АВАХ, ТҮҮНИЙ ЗАХИРАН ЗАРЦУУЛАЛТ

Зөвлөмж 12. Хууль зөрчиж хандив тусламж авах, хандивлагч этгээдтэй гэрээ байгуулах, түрээслэгчээс хандив авах, хандив тусламжийн бараа, эд материалыг байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгээгүй зөрчил түгээмэл гарч байгааг таслан зогсоох, холбогдох этгээдэд хариуцлага тооцох.

Тус эмнэлэгт 2019-2021 оны хооронд буюу 3 жилийн хугацаанд 20 компани, 1 төрийн бус байгууллагаас мөнгөн болон бараа материал, тоног төхөөрөмж зэрэг нийт 1,007,631,530 төгрөгийн дүнтэй хандив авсан байна. Уг хандивыг авахын өмнө тус хугацаанд ажиллаж байсан эмнэлгийн ерөнхий захирлууд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-т заасны дагуу хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага буюу Эрүүл мэндийн яамнаас хандив авч болох эсэх талаар албан ёсоор зөвшөөрөл аваагүй байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17.4-т "Энэ хуулийн 17.2-т заасан хандив, санхүүгийн туслалцаа авсан албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага хоёр жилийн хугацаанд хандивлагчтай


холбоотой аливаа шийдвэр гаргахыг хориглоно" гэж заасныг зөрчиж, дараах байдлаар хандивлагч аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулсан байна.

Мөн хандивлагч 15 байгууллагатай бараа материал худалдан авах гэрээ байгуулсан байх ба зарим хандив өгсөн байгууллага УНТЭ-ээс зарласан тендэрт байнга шалгарч байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11-д заасан "олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэх ойлгогдохуйц нөхцөл байдал"-ыг бий болгосон байна. Тухайлбал, хандивлагч "Ирмүүн бар" ХХК нь 2019 онд 109,952,621 төгрөг, 2020 онд 422,514,017 төгрөг, 2021 онд 79,774,582 төгрөгийн засварын ажлын тендэрт шалгарч, ажил гүйцэтгэсэн байна.

Хандивлагч байгууллагатай гэрээ байгуулсан байдлыг авч үзвэл:

	Компанийн нэр	2019		2020		2021	
		Хандивын хэмжээ	Төндөр авсан	Хандивын хэмжээ	Төндөр авсан	Хандивын хэмжээ	Төндөр авсан
1.	Ирмүүн бар ХХК	-	109,952,621	211,569,047.00	422,514,017	-	79,774,582
2.	Шинэ эрэн медикал ХХК	-	147,318,678	166,200,000.00	564,679,789	-	335,829,785
3.	Магнай Трейд ХХК	831,100.00	-	841,000.00	29,643,999	690,000.00	25,189,983
4.	Эм Эн Жи Би ХХК	-	93,341,145	-	144,987,330	481,200.00	313,850,000
5.	Монос Фарм трейд ХХК	-	1,163,830,174	7,749,000.00	60,205,400	-	37,946,820
6.	Евро фарм ХХК	-	405,425,888	790,000.00	145,113,100	-	171,413,900
7.	Твшин Энэрэл ХХК	-	-	2,300,000.00	12,072,500	-	8,820,000
8.	Тавин ус ХХК	-	61,495,650	1,500,000.00	105,090,045	1,944,000.00	131,365,800
9.	Монфа трейд ХХК	-	253,892,395	170.00	258,098,149	-	180,111,682
10.	Монгол Эм Импэкс Концерн ХХК	-	714,128,625	33,414,400.00	441,725,850	-	569,277,592
11.	Нахаа фарм ХХК	-	-	-	209,886,920	2,707,500.00	207,541,000
12.	Ивээлт-гүн	-	172,600,000	-	-	2,400,000.00	2,700,000
13.	Сүвэн Уул ХХК	-	-	-	30,955,471	1,191,666	367,946,250
	Нийт	831,100.00	2,949,557,776	481,444,050.00	2,424,972,570	8,397,700.00	2,429,070,094

График: Хандив авсан хэмжээ



Түрээслэгч нараас хандив авч гэрээ байгуулсан байдал:

Түрээслэгчийг сонгон шалгаруулахдаа тус эмнэлгийн барилгад хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгж байгууллагыг сонгон шалгаруулсан зөрчил гарсан байна. Тухайлбал, Эмнэлгийн байр талбайг 2020 онд түрээслэх сонгон шалгаруулалт зарлах даа "... одоо үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагууд тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн болно. Тухайн байршилд шалгарсан аж ахуйн нэгж байгууллага тухайн компанийн оруулсан хөрөнгө оруулалтыг шийдвэрлэж дууссанаар гэрээ хийгдэх нөхцөл

бүрдэнэ." гэж заасан нь хээл хахууль авах, өгөх нөхцөл байдлыг бүрдүүлсэн, иргэн аж ахуйн нэгжээс Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан "хандив авахтай холбогдсон хязгаарлалт"-ыг зөрчих нөхцөлийг бүрдүүлэн, хандивлагчид боломж олгож хандив өгөөгүй иргэн, аж ахуйн нэгжийг эрхийг хязгаарласан байна.

Хөрөнгө оруулалт хийсэн байгууллагатай гэрээ байгуулсан байдал:

№	Хуулийн этгээдийн нэр	УНТЭ-ийн барилгад оруулсан хөрөнгө оруулалтын мэдээлэл	УНТЭ-ээс хөрөнгө оруулсан этгээдтэй холбоотой шийдвэр гаргасан байдал
1	Мөнхийн Тун ХХК	Эмийн сан өргөтгөл шинээр хийхэд 31,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.	2020.04.01-ний өдөр УНТЭ-ээс түрээслэх талбайн зарлалд "Д блок-Эргэлтийн хэсгийн 1 дүгээр давхрын өргөтгөлд байрлах 24,0 м.кв талбай бүхий өрөө-Мөнхийн тун мед ХХК /эмийн сан/, Өргөтгөл хийхэд нийт хөрөнгө оруулалт 31,4 сая төгрөг" гэж оруулсан. Сонгон шалгаруулалтад тус компани шалгарч, одоо эмийн сангийн зориулалтаар түрээслэж байна.
2	Өлзийдэн ХХК	Амбулаторид байрлах байршил өөрчлөгдсөнөөр шинээр байр талбай тохижуулсан 20,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.	2020.04.01-ний өдөр УНТЭ-ээс түрээслэх талбайн зарлалд "С блок-Амбулаторийн 1 давхарт байрлах 34,5 м.кв талбай бүхий өрөө-Өлзийдэн ХХК /эмийн сан/, Амбулаторид байрлах байршил өөрчлөгдсөнөөр шинээр байр талбай тохижуулсан 20,3 сая төгрөг" гэж оруулсан. Сонгон шалгаруулалтад тус компани шалгарч, одоо эмийн сангийн зориулалтаар түрээслэж байна.

Мөн хувийн аж ахуйн нэгжүүдээс хөрөнгө оруулалт хийхдээ өмчлөгчөөс зөвшөөрөл авсан эсэх нь тодорхойгүй (баримт материал гаргаж өгөөгүй), оруулсан хөрөнгийг өмчдөө бүртгэж аваагүй байна.

Тухайлбал, 2020 онд хийгдсэн" Мөнхийн Тун" ХХК-ийн 31,4 сая төгрөгөөр эмийн сангийн өргөтгөл шинээр хийсэн, "Марал хатан ХХК"-ийн 34,5 сая төгрөгөөр өргөтгөл шинээр хийсэн, "Өлзийдэн" ХХК-ийн 20,3 сая төгрөгөөр амбулаторид байрлах байршил өөрчлөгдсөнөөр шинээр байр талбай тохижуулсан хөрөнгө оруулалт, "Хан Баян түшиг Фарм" ХХК-ийн 85,4 сая төгрөгөөр эргэлтийн хэсэг болон зүүн байрны залгаа хэсгийн өргөтгөлд хийсэн хөрөнгө оруулалт буюу засвар үйлчилгээг одоог хүртэл байгууллагын хөрөнгөд бүртгэгдээгүй байна.

Зөвлөмж 13. Нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдийг хууль, Засгийн газрын тогтоолд заасны дагуу тэмдэглэн өнгөрүүлэх, санхүүжилтийг хууль тогтоомж зөрчиж цуглуулахгүй байх, зөрчил гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцох.

Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам"-ын 1.4-т "Байгууллагын тэгш ойг байгуулагдсан өдрөөс хойш 50 болон түүнээс дээш 10 жилийн давтамжтай тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон аймаг, нийслэлийн Засаг даргын зөвшөөрлийг үндэслэн тухайн байгууллагын удирдлага холбогдох шийдвэр гаргаж тэмдэглэнэ." гэж заасан. Гэтэл УНТЭ нь 2020 оны 10 дугаар сард эмнэлэг үүсэн байгуулагдсаны түүхт 95 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулсан байна.

Эмнэлэг үүсэн байгуулагдсаны 95 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах зардлыг УНТЭ -ийн ТУЗ-ийн даргын 17 дугаар тогтоолоор 39,000,000 төгрөгөөр баталж, ЭМД-ийн орлогоос хөтөлбөр төслийн бараа ажил үйлчилгээний бусад зардлын ангилалд хуваарилж баталсан, өөр нэг эх үүсвэр нь тус эмнэлгийн байр талбайг түрээслэгч 9 аж ахуй нэгжээс болон тендерт шалгарч ажил гүйцэтгэдэг компаниас хандив авч тэмдэглэсэн байна. ЭМД-ийн орлогоос төсөвлөсөн зарцуулалтын жагсаалттай танилцахад бэлэг дурсгал, энгэрийн тэмдэг, хоол, цай гэх мэт зүйлд зарцуулсан байна.

ЭМД-ийн сангийн орлогоос ойн арга хэмжээнд зарцуулсан байдлыг авч үзвэл:

Огноо	Утга	Санхүүжилт	Зарлага
	Санхүүжилт	39,000,000.00	
2020/10/21	Цайны зардал		1,500,000.00
2020/10/21	Хоолны зардал		16,500,000.00
2020/10/21	Нэвтрүүлгийн зардал		800,000.00

2020/10/21	Бэлэг дурсгалын зардал		2,500,000.00
2020/10/21	Бэлэг дурсгалын зардал		5,000,000.00
2020/10/21	Шатахууны зардал		800,000.00
2020/10/21	Энгэрийн тэмдгийн үнэ		330,000.00
2020/10/21	Энгэрийн тэмдгийн үнэ /шинэ логотой/		781,000.00
2020/10/21	Туг, тугийн суурь		119,000.00
2020/10/23	Нэвтрүүлгийн зардал		800,000.00
2020/10/23	Гэрэл, зургийн зардал		1,100,000.00
2020/10/28	Хэвлэлийн зардал		4,500,000.00
2020/10/28	Хулдаасан хэвлэл, стендийн зардал		1,050,000.00
2020/11/25	Баннер, суурилуулалтын үнэ		2,530,000.00
Нийт			38,310,000.00

Ойн арга хэмжээ зохион байгуулсан асуудлыг дүгнэхэд тус эмнэлгийн ТУЗ болон эмнэлгийн удирдах албан тушаалтнууд тэгш ойтой жил тэмдэглэх, бусад үед ойн арга хэмжээг тэмдэглэхгүй байх Засгийн газрын тогтоолыг зөрчиж ЭМД-ийн орлогоос 38,310.000 төгрөгийг зориулалт бусаар захиран зарцуулсан байна. Мөн эмнэлгийн Төлөвлөлт, үйл ажиллагаа ажиллагаа эрхэлсэн дэд захирал Б.Түвшинтөрийн санаачилга, удирдан зохион байгуулалтаар тус эмнэлгийн байр талбайг түрээслэгч 9 аж ахуйн нэгж болон засварын ажлын тендерт шалгарч ажил гүйцэтгэж байгаа 1 компаниас хандив өгөхийг хүсэж 28,500.000 төгрөгийг мөнгөн кассаар дамжуулаагүй, төрийн сангийн төвлөрүүлэлгүй захиран зарцуулж, Төсвийн тухай хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчсөн байна.

Мөн Улсын нэгдүгээр төв эмнэлэг үүсэн байгуулагдсаны 95 жилийн ой 2020 онд тохиосонтой холбогдуулж, түрээсийн гэрээ байгуулсан аж ахуйн нэгж болон бараа ажил үйлчилгээ худалдан авсан харилцагч компаниас хандив авсан байна.

Эмнэлгийн Төлөвлөлт, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал Б.Түвшинтөр, эдийн засаг, маркетингийн албаны даргыг хавсран гүйцэтгэгч С.Батцэнгэл нар түрээслэгч аж ахуйн нэгжийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулан, хандив өгөхийг хүсэж, хандивын мөнгийг төрийн сангаар дамжуулалгүй, нийт 28,500.000 төгрөгийг бэлнээр авсан байна.

Хандив хүсэж авсан энэ үйлдэл нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасан "Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно" гэж заасныг, хандивын мөнгийг төрийн сангаар дамжуулалгүй бэлнээр авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-т "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх" гэж, 25 дугаар зүйлийн 25.7-д "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана." гэж, 25.8-д "Төсвийн ерөнхийлөн захирагч тусламж, хандив авсан тухай баримтын хувийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд нэг сарын дотор хүргүүлнэ." гэж, 35 дугаар зүйлийн 35.2-т "Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Хандив өгсөн аж ахуйн нэгжийн нэрс, хандивын хэмжээ

	Аж ахуйн нэгжийн нэр	Эмнэлэгтэй харилцсан байдал	Хандив өгсөн дүн
1	Ирмүүн бар ХХК	Тендерт 2019-2021 оны хооронд шалгарч 612,241,220 төгрөгийн засварын ажил гүйцэтгэсэн	1,000.000
2	Отгонбуянт хүрээ ХХК	Эмнэлгийн байр талбайг түрээсэлж эмийн сан ажиллуулдаг	3,500.000
3	Итгэлт анд ХХК	Эмнэлгийн байр талбайг түрээсэлж Цайны газар ажиллуулдаг	2,000.000
4	Ану Тулгат ХХК	Эмнэлгийн байр талбайг түрээсэлж Эмийн сан ажиллуулдаг	4,000.000

5	Хийлс эйд ХХК	Эмнэлгийн байр талбайг түрээсэлж хувийн эмнэлэг буюу дүрс оношилгоо үйл ажиллагаа явуулдаг	3,000.000
6	Мөнхийн тун ХХК	Эмнэлгийн байр талбайг түрээсэлж Эмийн сан ажиллуулдаг	3,000.000
7	Өлзий тун ХХК	Эмнэлгийн байр талбайг түрээсэлж Эмийн сан ажиллуулдаг	3,000.000
8	Бест арома ХХК	Эмнэлгийн байр талбайг түрээсэлж Кофе шоп ажиллуулдаг	3,000.000
9	Хараа Маркет ХХК	Эмнэлгийн байр талбайг түрээсэлж Хүнсний дэлгүүр ажиллуулдаг	3,000.000
10	Гоозоорой ХХК	Эмнэлгийн байр талбайг түрээсэлж Кофе шоп ажиллуулдаг	3,000.000
Нийт			28,500.000

Түүнчлэн уг хандив, дэмжлэгийг авахын өмнө өөрийн удирдлага, эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл аваагүй нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-т "Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна." гэж заасныг зөрчсөн байна.

Хандивын хөрөнгийн зарцуулалтын байдалтай танилцахад амралтын газрын төлбөр, хоол, чихэр, жимс, байрны түрээс, хамтлаг дуучид, тээврийн хөлс гэх мэт баярлаж зугаацах арга хэмжээнд зарцуулсан байна.

Хандивын хөрөнгийн зарцуулалтын дэлгэрэнгүйг доорх хүснэгтээс харуулбал:

Хандиваар гарсан зардал		
Огноо	Гүйлгээний утга	Зарлага
2020/10/10	Тавгийн чихэр, жимсний үнэ	2,500,000.00
2020/10/10	Ундаа, тавгийн чихэр	8,090,520.00
2020/10/10	Айраг амралтад	250,000.00
2020/10/10	Жимс, хиамны үнэ	3,312,500.00
2020/10/10	Нэг удаагийн аяга тавгийн үнэ	189,630.00
2020/10/10	Тэмцээний шагналын зардал	500,000.00
2020/10/10	Нэг удаагийн аяганы үнэ	100,000.00
2020/10/10	Хийл хөгжмийн зардал	300,000.00
2020/10/10	Баяр хурлын айргийн үнэ	200,000.00
2020/10/10	Амралт гэрний хөлс	50,000.00
2020/10/10	Ааруул, салфетикийн үнэ	190,000.00
2020/10/10	Тээврийн хөлс	800,000.00
2020/10/10	Түрээсийн зардал	4,320,000.00
2020/10/10	Хамтлаг дуучид	4,680,000.00
2020/10/18	Төрийн санд төвлөрүүлсэн	3,017,350.00
Дансны дүн:		28,500,000.00

ТАВ ДУГААР ХЭСЭГ. ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР

Зөвлөмж 14. "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам"-д заасны дагуу эмнэлгийн авто зогсоолыг төлбөргүй болгох, хууль зөрчиж төлбөртэй үйл ажиллагаа явуулж буй үйлдлийг таслан зогсоох.

Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-т "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам, жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төлбөрийн жишиг хэмжээг санхүүгийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална." гэж заасны дагуу Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 12 сарын 03-ны өдрийн "Жагсаалт, журам батлах тухай" А/470 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам"-ыг баталсан байна. Тус журмын 4.4-т "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага нь иргэдээс жагсаалтад зааснаас бусад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон анхан шатны маягт,

бие засах газар, нөмрөг, улавч, машины зогсоол, халатны үнэ, өвчтөн шилжүүлэх болон шинжилгээний бичиг олгох, хувцас өлгөх зэрэг нийтлэг үйлчилгээнээс төлбөр авахгүй.” гэж заасан.

УНТЭ-ийн эмнэлгийн хашааны зүүн хойд хэсэг болон урд талын зогсоолд “Төгс гэрэлт цамхаг” ХХК нь тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоолын үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд ажлын хэсгээс газар дээр нь танилцахад эмнэлгийн урд хэсгийн зогсоолд Нийслэлийн автозамын хөгжлийн газартай гэрээ байгуулж ажиллуулдаг, харин эмнэлгийн зүүн хойд хэсгийн зогсоолыг сонгон шалгаруулалтгүйгээр, гэрээ байгуулалгүй үйл ажиллагаа явуулж байгаа зөрчил илэрсэн. Хэдийгээр “Төгс гэрэлт цамхаг” ХХК нь Нийслэлийн автозамын хөгжлийн газартай гэрээ байгуулан ажиллаж байгаа боловч зогсоолын талбай нь тус эмнэлгийн эзэмшлийн газар байна. Мөн төлбөртэй зогсоолоор үйлчлүүлсэн орлогыг Нийслэлийн автозамын газар, эсхүл Улсын нэгдүгээр төв эмнэлгийн аль ч авч байсан ялгаагүй иргэд зогсоолын төлбөрийг төлөх тул “Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам”-ын 4.4-т заасныг зөрчиж байна гэж үзэхээр байна.

Зөвлөмж 15. Хуулиар захиргааны хэм хэмжээний акт тогтоох эрхийг олгоогүй байхад дүрэм, журам батлан мөрдүүлж, төлбөр, хураамж тогтоосон холбогдох шийдвэрийг хүчингүй болгох, зөрчлийг арилгах, таслан зогсоох, давтан гаргахаас урьдчилан сэргийлэх.

Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-д “Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам, жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төлбөрийн жишиг хэмжээг санхүүгийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэж заасны дагуу Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 12 сарын 03-ны өдрийн А/470 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам”, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 264/А/293 дугаар тушаалаар баталсан “Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай” зэрэг шийдвэрүүдийг улсын хэмжээнд мөрдөж байна.

Гэтэл УНТЭ-ийн Ерөнхий захирлын 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/76 дугаар “Тусламж, үйлчилгээний санхүүжилтийн журам батлах тухай” тушаалаар “Тусламж, үйлчилгээний санхүүжилт”, “Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 264/А/293 тоот тушаалд заагдсан болон нэмэлтээр хийгдэх тусламж үйлчилгээний жагсаалт, тариф”, “ЭМД-тай хэвтэн эмчлүүлэгчдээс төлөх эмчилгээний зардлын 15 хувийн жагсаалт”, “Төсөвт нийцүүлэн эмнэл зүйн албаны ажиллах орны тоо, нөхцөл сайжруулсан орны тоо, мөрдөх тариф”, “Ачаалал, хүлээгдэл, зохиомол эрэлт ихтэй, өндөр өртөгтэй, өнчин тоног төхөөрөмжийн оношилгоо, шинжилгээний жагсаалт, зохицуулалт, тариф”, “Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгооны багцуудын үнийн жишиг тариф”-ыг тус тус баталсан байна. Тус тушаалыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх ажлыг зохион байгуулах, дээд шатны байгууллага, албан тушаалтнаас бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан шийдвэр, түүгээр зохицуулах харилцааг давхардуулан журамласан тохиолдолд хүчингүй болгох шаардлагатай.

Түүнчлэн тус эмнэлгийн ТУЗ-ийн 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн “Төсвийн зарлагын сар, улирлын хуваарь шинэчлэн баталж, орлого нэмэгдүүлэх тухай” 07 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар “УНТЭ-ийн VIP тасгийн төлбөртэй өрөөний орны үнийн тариф” зэргийг тогтоохдоо Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 264/А/293 дугаар “Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай” тушаалаар тогтоосон төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэн тогтоож, иргэдэд чирэгдэл үүсгэсэн байна. Тухайлбал,

VIP тасгийн төлбөртэй өрөөний орны үнийн тарифт 1 өрөөний 1 орны үнийг өрөөний орны тооноос хамааруулан 80,000-210,000 төгрөг байхаар тогтоосон нь хамтарсан сайдын тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ”-нд заасан хамгийн өндөр үнэтэй люкс өрөөний үнээс даруй 30,000-160,000 төгрөгөөр өндөр байна. Иймд УНТЭ-ийн ТУЗ-ийн 2021 оны 07 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар

баталсан "УНТЭ-ийн VIP тасгийн төлбөртэй өрөөний орны үнийн тариф" нь хуулиар захиргааны хэм хэмжээний акт тогтоох эрх олгоогүй байхад батлан гаргасан, дээд шатны байгууллага, албан тушаалтнаас бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан шийдвэр, түүгээр зохицуулах харилцааг давхардуулан журамласан, үндэслэлгүйгээр төлбөр хураамж тогтоосон, иргэдэд дарамт шахалт үүсгэсэн байх тул хүчингүй болгох шаардлагатай байна. Мөн эмнэлгийн зүгээс ТУЗ-ийн тогтоол гарахаас өмнө буюу төлбөрийн жишиг хэмжээ батлагдаагүй байхад 2020 оноос эхлэн хууль бус өндөр төлбөрийг иргэдээс авч, иргэдэд дарамт үзүүлж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан "Төлбөр авахтай холбогдсон хязгаарлалт"-ыг зөрчсөн байна.

ЗУРГАА ДУГААР ХЭСЭГ. ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ


Зөвлөмж 16. Албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх, ёс зүйн зөрчил гаргасан этгээдэд тухай бүр хариуцлага ногдуулж хэвших.

Нэр бүхий иргэнээс УНТЭ-т 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдөр УНТЭ-ийн Зүрхний төвийн их эмч Б.Булгантай холбогдуулж, албан бус төлбөр авсан, эмнэлгийн тусламж үйлчилгээний талаар үнэн бодитоор мэдээлээгүй тухай гомдлыг эмнэлгийн "Ёс зүйн хороо"-нд гаргасан байна. Гомдолд дурдагдсан асуудлыг судлан үзэхэд авлигын гэмт хэргийн шинжтэй хэд хэдэн үйлдэл байх ба тухайн үед эмнэлгийн ёс зүйн салбар хороо уг гомдлыг Авлигын эсрэг хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй." гэж заасны дагуу Авлигатай тэмцэх газарт шалгуулахаар хүргүүлээгүй байна. Ёс зүйн хорооноос тухайн үед эмч Б.Булганы үйлдэлд "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн 3.1.1а, 3.1.2а, 3.1.4б, 3.1.5а, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийн 3.1, 4.2, 4.1.15, 4.8, 5.4, 8.2, 8.11, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 60.1.1, 60.1.9, 69.2.5, 69.2.18-ыг зөрчсөн гэж үзэж, ажлаас халах саналыг УНТЭ-ийн захиргаанд хүргүүлсэн боловч эмч Б.Булганд сануулах сахилгын шийтгэл оногдуулсан байна.

Зөвлөмж 17. Төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй, шударга, шуурхай, хариуцлагатай, ёс зүйтэй, ажил хэрэгч байдлыг хангах, хуулиар хүлээсэн үүргийн дагуу мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангах, холбогдох мэдээллийг тухай бүр байршуулж хэвших.

Авлигатай тэмцэх газраас гаргасан төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг үнэлэх аргачлалын дагуу хуулиар хүлээсэн үүрэг буюу мэдээлбэл зохих мэдээ, мэдээллийг цахим хуудсанд байршуулсан эсэхийг үнэлэх, тухайн байгууллагын онцлог, чиг үүргээс хамаарч үнэлгээг 47 шалгуур үзүүлэлттэй боловсруулан хэрхэн хангасан эсэхийг хянан шинжлэв.

Шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээлэл байршуулсан эсэхийг харгалзан 0-3 оноо өгөх замаар нийт 0-100 хүртэл оноогоор үнэлгээ хийв. Үнэлгээг 2021 оны 10 сарын байдлаар хийхэд 47.1 оноо буюу хангалтгүй үнэлүүлэв. Авлигатай тэмцэх газраас өмнө нь 2015 онд тус эмнэлэгт удирдамжийн дагуу ажиллаж цахим хуудсанд үнэлгээ хийхэд мөн л 2015 онд 25 оноо, 2016 онд дахин үнэлэхэд 66.6 оноогоор үнэлэгдэж байв. Тухайн үед мэдээллийн ил тод байдлыг сайжруулах чиглэлээр албан зөвлөмж, зөрчил арилгуулах албан бичиг хүргүүлж байсан боловч 2021 оны байдлаар одоог хүртэл хуулиар хүлээсэн үүрэг буюу иргэд олон нийтэд ил тод нээлттэй байршуулах мэдээллийг ил тодоор хуулийн хугацаанд мэдээлж хэвшээгүй, 2016 оноос хойш ил тод байдлыг сайжруулах чиглэлээр ажил арга хэмжээг зохион байгуулаагүй байна.



Байршуулаагүй байгаа мэдээллийг дурдвал, үйл ажиллагааны талаарх мэдээлэл буюу удирдлагын тушаал шийдвэр, ажлын төлөвлөгөө, тайлан, төлбөртэй тусламж үйлчилгээний жагсаалт, ажилтан сонгон шалгаруулах журам, сул орон тооны зарыг ил тод байршуулаагүй, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлаагүй байна. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн <http://unte.moh.gov.mn/> цахим хуудасны доод хэсэгт "Хууль тогтоомж" туслах цэсэд Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем Legalinfo.mn цахим хуудасны холбоосыг оруулсан байна. Харин тусгайлан үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, тогтоомж /хуульчилсан акт/ Засгийн газар, яамд, Төрийн өмчийн хорооны шийдвэр, байгууллагын дотоодод мөрдөгдөх дүрэм, журам, заавар зэргийг байршуулаагүй байна.

Зөвлөмж 18. "Онч шийдэл" төрийн бус байгууллагаас 2019 онд хийсэн авлигын эрсдэлийн үнэлгээний мөрөөр хүргүүлсэн "Зөвлөмж"-ийг хэрэгжилтийг эрчимжүүлэх.

Авлигатай тэмцэх газрын захиалгаар Улсын нэгдүгээр төв эмнэлэг дэх авлигын эрсдэлийн судалгааг 2019 онд "Онч шийдэл" төрийн бус байгууллага хийсэн ба үнэлгээний мөрөөр 12 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлж, түүний биелэлтийг жил тутам гаргуулж, дүн шинжилгээ хийх арга хэмжээг зохион байгуулж байна. Энэ хүрээнд 2021 оны 04 дүгээр сарын байдлаар зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэхэд бүрэн хэрэгжсэн 2, хэрэгжих шатанд гэж дүгнэгдсэн 8, хэрэгжилт хангалтгүй 1, хэрэгжээгүй 1 заалт, дунджаар 57.5 буюу хангалтгүй хэрэгжилттэй байх тул хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авах шаардлагатай байна.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР